



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2019 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

“Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 9.1.3 дах заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2014 оны 10 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Т.НАРАНМАНДАХ



**Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт,
засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн
нөхцөл, шаардлага**

1. Ерөнхий нөхцөл

- 1.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Төрөөс харилцаа холбооны талаар баримтлах бодлого 2017-2025 он, Харилцаа холбооны зохицуулах хороо (Цаашид Зохицуулах хороо гэх)-ноос баталсан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үндэсний стандарт, норматив баримт бичгүүд болон бусад холбогдох хууль, дүрэм, журмыг дагаж мөрдөнө.
- 1.2. Энэхүү тусгай зөвшөөрлийн хүрээнд хот суурин, барилга байгууламж хооронд харилцаа холбооны худаг, сувагчлал, шилэн болон зэс кабель шугам, агаарын шугам угсарч, суурилуулах, барилгын доторх холбооны сувагчлал, сүлжээ байгуулж, тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалт, холболтын ажил үйлчилгээ эрхлэхийг зөвшөөрнө. Харин холбооны цамхаг байгуулж, түүн дээр харилцаа холбооны тоног төхөөрөмж угсарч суурилуулах ажил үйлчилгээ эрхлэх бол тусгай зөвшөөрөлд нэмэлт хийлгэнэ.
- 1.3. Зөвхөн барилгын дотор харилцаа холбооны сувагчлал, сүлжээ байгуулж, тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалт, холболт хийх ажил үйлчилгээ эрхлэх тохиолдолд Харилцаа холбооны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт заасны дагуу Зохицуулах хороонд бүртгүүлж, бүртгэлийн гэрчилгээ авна.
- 1.4. Цамхаг байгуулж, түүн дээр харилцаа холбооны тоног төхөөрөмжийг угсарч, суурилуулах ажил гүйцэтгэх тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох ба ажил үйлчилгээг өргөжүүлж, кабель шугамын угсралт суурилуулалт хийх тохиолдолд тусгай зөвшөөрөлд нэмэлт хийлгэнэ.
- 1.5. Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, тусгай зөвшөөрөлд нэмэлт хийхэд Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.11 дэх заалтад заасан зохицуулалтын үйлчилгээний хөлсөд мөн холбогдох нэмэлт, өөрчлөлт орно.
- 1.6. Цамхаг байгуулж, түүн дээр харилцаа холбооны тоног төхөөрөмжийг угсарч, суурилуулах тусгай зөвшөөрлийн хүрээнд 30 хүртэлх метрийн өндөртэй цамхаг угсралтын ажил гүйцэтгэнэ. Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсэгт заасны дагуу 30 метрээс дээш цамхаг угсралтын ажил гүйцэтгэх бол барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл нэмж авах шаардлагатай.
- 1.7. Харилцаа холбооны тухай хуулийн 15.1.3 дэх заалтыг үндэслэн тусгай зөвшөөрөл авснаас хойш 1 жилийн дотор үйл ажиллагаа эхлүүлсэн байх шаардлагатай.

2. Тусгай зөвшөөрөл олгоход тавигдах нөхцөл

- 2.1. Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа, ажил үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай өөрийн эзэмшлийн болон гэрээний нөхцлөөр ашиглах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг талаарх нотлох баримт, гэрээг тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд хавсаргаж ирүүлнэ.
- 2.2. Тусгай зөвшөөрөл олгоход шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн иж бүрдэл нь энэхүү нөхцөл, шаардлагын хавсралт 1-д тусгасан нөхцөл шаардлагыг хангана.
- 2.3. Тусгай зөвшөөрлийн хүрээнд гүйцэтгэх ажлыг хариуцан ахлаж ажиллах ерөнхий инженертэй байх бөгөөд ерөнхий инженер нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэгтэй эсвэл түүнтэй дүйцэхүйц олон улсын зэрэгтэй байна.

- 2.4. Тусгай зөвшөөрлийн хүрээнд ажлыг гардан гүйцэтгэх харилцаа холбоо, мэдээллийн технологийн инженер, кабельчдаас бүрдсэн 2 болон түүнээс дээш үндсэн ажилтантай байх бөгөөд холбогдох мэргэжлийн сургалтад хамрагдаж сертификат авсан байна.
- 2.5. Тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргагч нь тухайн үйл ажиллагааны чиглэлээр гэрээт ажилтан авч ажлуулж болно.
Инженер техникийн ажилтнууд нь тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргасан чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байх ба гүйцэтгэсэн ажлын акт, захиалагчийн тодорхойлолт зэргээр нотолсон мэдээллийг тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд хавсаргасан байна.

3. Үйл ажиллагаанд тавигдах шаардлага

- 3.1. Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэхдээ Зохицуулах хорооноос баталсан норматив баримт бичиг, энэхүү нөхцөл, шаардлагын хавсралт 2-т заасан үндэсний стандартуудыг мөрдлөг болгож ажиллах үүрэг хүлээнэ.
- 3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 2-р зүйлд заасан шаардлагыг хангасан байх ба инженер, техникийн ажилтнуудтай Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу гэрээ байгуулж, нийгмийн даатгал төлдөг байна.
- 3.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь инженер техникийн ажилтнуудад хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх зорилгоор тогтмол сургалт, зөвлөгөө өгч тэмдэглэл үйлдсэн байна.

4. Стандарт технологийн мөрдөлт

- 4.1. Тухайн ажил үйлчилгээг хийж гүйцэтгэхдээ олон улсын болон үндэсний стандартууд, норматив баримт бичгийг мөрдлөг болгож ажиллах үүрэгтэй.
- 4.2. Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын дотоод журмыг боловсруулж, мөрдөнө.
- 4.3. Угсралт суурилуулалтын ажил нь үндэсний стандарт, зураг төсөл, техникийн нөхцлийн дагуу хийгдэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих дотоод дүрэм, журмыг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөнө.
- 4.4. Энэхүү нөхцөл, шаардлагын 4.3-т заасан шаардлагад хяналт тавьсан протокол, акт, тайлан мэдээллийг архивлаж хадгалана.
- 4.5. Өөрийн үйл ажиллагааны чиглэлээр батлагдсан дүрэм, журам, үндэсний стандарт, норматив баримт бичгүүдийн санг үүсгэх, тухай бүр шинэчлэн баяжуулах, гарын авлага, үзүүлэн таниулах материал бэлтгэн ажилтнуудаа тогтмол сургалт мэдээллээр хангах арга хэмжээг авч ажиллана.

5. Мэдээлэл ирүүлэх, архивлах

- 5.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах мэдээллүүдийг 3-аас доошгүй жилийн хугацаатайгаар архивладаг байна.
 - 5.1.1. Угсралт, суурилуулалтын ажилд хяналт тавьсан протокол, акт, тайлан мэдээлэл;
 - 5.1.2. Ажилчидтай хийсэн хөдөлмөрийн гэрээ, нийгмийн даатгал төлсөн баримт, тайлан мэдээ;
 - 5.1.3. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заавар, зөвлөгөө өгсөн тэмдэглэгээ.
- 5.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хороонд хагас жил тутамд тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан хугацаанд статистик тайлан мэдээллийг маягтын дагуу үнэн, зөв ирүүлнэ.

“Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын Нэгдүгээр хавсралт



Техник, хэрэгслийн иж бүрдэлд тавигдах үндсэн нөхцөл шаардлагууд

Нэг. Гадна холбооны угсралт сууриалт, засвар үйлчилгээний төрлийн зөвшөөрөл болон дотор холбооны угсралт, суурилуулалт, засвар үйлчилгээний бүртгэлийн гэрчилгээ авах хуулийн этгээдэд тавигдах нөхцөл:

Өөрийн эзэмшлийн техник хэрэгсэл:

1. Шилэн кабелийн залгааны машин;
2. Кабелийн ролик;
3. Хөдөлмөр аюулгүй байдлын хэрэгсэл;
4. Телешк;
5. Бүтүүмжлэл бүхий машин (шилэн кабелийн залгаа, муфьт хийхэд зориулагдсан).

Түрээсийн гэрээгээр ашиглаж болох техник, хэрэгсэл:

6. Цахилгаан үүсгүүр буюу мотор, дизель үүсгүүр;
7. Экскаватор, трактор, кран.

Хоёр. Цамхаг байгуулж, түүн дээр холбооны тоног төхөөрөмж угсарч, суурилуулах ажил үйлчилгээ эрхлэх бол тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл:

Өөрийн эзэмшлийн техник, хэрэгсэл:

1. Шилэн кабелийн залгааны машин;
2. Кабелийн ролик;
3. Хөдөлмөр аюулгүй байдлын хэрэгсэл;
4. Цахилгаан үүсгүүр буюу мотор, дизель үүсгүүр;
5. Телешк;
6. Бүтүүмжлэл бүхий машин (шилэн кабелийн залгаа, муфьт хийхэд ашиглах);

Түрээсийн гэрээгээр ашиглаж болох техник, хэрэгсэл:

7. Суурь миксер;
8. Хэв шахмал;
9. Вибратор;
10. Кран бүхий машин механизм;
11. Экскаватор.

– о О о –

“Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн
суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай
зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын
Хоёрдугаар хавсралт



Үйл ажиллагаандаа мөрдөх стандартын жагсаалт

Гадна холбооны угсралт суурилалт, засвар үйлчилгээний болог цамхаг байгуулж, түүндээр холбооны тоног, төхөөрөмж угсарч, суурилуулах ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл болон дотор холбооны угсралт, суурилуулалт, засвар үйлчилгээний бүртгэлийн гэрчилгээ эзэмшигчид үйл ажиллагаандаа заавал мөрдөх ёстой үндэсний стандартууд:

1. MNS 5017:2001 Телефон сүлжээний сувагчлалд зориулсан хуванцар яндан. Техникийн ерөнхий шаардлага
2. MNS 5276:2013 Холбооны кабелийн суурилуулалт. Ерөнхий шаардлага
3. MNS 5277:2003 Кабелийг залгах, муфтлэх. Ерөнхий шаардлага
4. MNS 5279:2013 Телефоны хуваарилах шүүгээ, 100 хосын төгсгөлийн блок суурилуулалт, Ерөнхий шаардлага
5. MNS 5280:2003 Салбар кабелийн төгсгөлийн төхөөрөмжийн суурилуулалт. Ерөнхий шаардлага
6. MNS 5281:2003 Кабелийн цахилгааны үзүүлэлт. Ерөнхий шаардлага
7. MNS 5207:2011 Шилэн кабелийн суурилуулалт. Техникийн шаардлага
8. MNS 5317:2011 Оптик шугамын төгсгөлийн төхөөрөмж, ашиглалт үйлчилгээний хэмжилт, суурилуулалтад тавих ерөнхий шаардлага
9. MNS 5278:2012 Шилэн кабелийг залгах, муфтлэх. Ерөнхий шаардлага
10. MNS 5471:2005 Барилгын дотор холбоо, дохиоллын сувагчлал ба кабелийн угсралт
11. MNS 5696:2006 Телефон холбооны олон хосын нам үезлэлийн кабелийг цахилгааны кабельтай огтлолцох болон зэрэгцүүлэн суурилуулахад тавих шаардлага
12. MNS 5843:2008 Хамгаалалтын дохиоллын тоног төхөөрөмжийн техникийн үндсэн үзүүлэлт. Угсралт суурилуулалт, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага
13. MNS 2361:1977 Дамжуулан нэвтрүүлэх радио зангилааны станц болон утсан холбооны суурин төхөөрөмжийн газардуулга. Эсэргүүцлийн хэмжээ
14. MNS 5762:2007 Цамхагт суурилуулсан антенн фидерийн байгууламж, Аюулгүй ажиллагааны шаардлага
15. MNS 5884:2008 Холбооны цамхаг байгуулахад тавих ерөнхий шаардлага
16. MNS 2978:1980 Холбооны, агаарын шугамын модон хөндлөвч
17. MNS 5596:2006 Цахилгаан холбооны сүлжээнд ажиллахад тавих аюулгүй ажиллагааны шаардлага
18. MNS 5740:2007 Тоон технологитой мэдээлэл холбооны тоног төхөөрөмжийн цахилгаан тэжээл. Техникийн ерөнхий шаардлага
19. MNS 1814:1979 Антеннийг цахилгаан бүдүүвчинд тэмдэглэх
20. MNS 3966:1987 Холбооны төмөр бетон угсармал худаг
21. MNS 4908:2017 Мэдээлэл холбооны сүлжээний гадна холбооны зургийн тэмдэглэгээ
22. MNS 5532:2016 Барилгын зураг. Мэдээлэл, холбоо, дохиоллын тоног төхөөрөмжийн тэмдэглэгээ
23. MNS 6305:2012 Холбооны кабель шугамын ажлын зураг төсөл
24. MNS 6423:2013 Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер. Ерөнхий шаардлага
25. MNS 6498:2015 Харилцаа холбоо, мэдээллийн технологийн тоног төхөөрөмжид тавих аюулгүй байдлын шаардлага
26. MNS 6544:2015 Шилэн кабелийг шалгах аргачлал

27. MNS 6580:2016 Орон сууцны барилгын мэдээлэл, холбооны суурин сүлжээний төлөвлөлт. Ерөнхий шаардлага
28. MNS 6581:2016 Орон сууцны барилгын мэдээлэл, холбооны суурин сүлжээний суурилуулалт. Ерөнхий шаардлага
29. MNS 6586:2016 Барилгын зураг. Барилга байгууламжийн мэдээлэл, холбоо, дохиоллын ажлын зураг төсөл боловсруулах. Ерөнхий шаардлага
30. MNS 6588:2016 Мэдээлэл холбооны суурин сүлжээний сувагчлалын хоолойд уян нийлэг дэд сувагчлал суурилуулах ерөнхий шаардлага
31. MNS 6589:2016 Мэдээлэл холбооны суурин сүлжээнд шилэн кабелийн бичил хоолойн сувагчлал суурилуулах ерөнхий шаардлага
32. MNS 6590:2016 Радио холбооны антен, фидерийн байгууламжид ажиллах аюулгүй ажиллагааны шаардлага
33. MNS 6597:2016 Автозам, төмөр зам хөндлөн гарах болон гүүрэн байгууламжид холбооны кабель шугамыг суурилуулах ерөнхий шаардлага
34. MNS 6668:2017 Холбооны худаг сувагчлалын байгууламжийн техникийн үзүүлэлт, суурилуулалтын шаардлага
35. MNS 6669:2017 Харилцаа холбооны зай тэжээлийн ба нөөц тэжээлийн төхөөрөмжийн өрөөний ерөнхий шаардлага

– о О о –